



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/790

Булган сум

Г Сумын Засаг дарга, тосгоны Захирагч нарын Г
2024 оны "Хамтран ажиллах гэрээ"-г дүгнэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.5 дахь хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.8 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргатай сумын Засаг дарга нар, тосгоны Захирагчийн 2024 онд "Хамтран ажиллах гэрээ"-г дүгнэсэн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2.Хамтран ажиллах гэрээний үнэлгээг үндэслэн сахилгын шийтгэлтэйгээс бусад сумын Засаг дарга нарт холбогдох журмын дагуу урамшуулал олгохыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3.Хамтран ажиллах гэрээг дүгнэсэн байдалд дүн шинжилгээ хийж, 2025 оны хамтран ажиллах гэрээг оны эхнээс заалт нэг бүрээр нь хяналтад авч биелэлтийг тооцож тайлагнахыг сумын Засаг дарга нар, тосгоны Захирагчид үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6324011-80

Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 24-ны/ний өдрийн ... А/790 дугаар
захирамжийн хавсралт



**Аймгийн Засаг даргатай сумын Засаг дарга, тосгоны Захирагч нарын
хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн үнэлгээ**

д/д	Сум, тосгоны нэр	Үнэлгээ /хувиар/
1	2	3
1	Бугат	88.34
2	Гурванбулаг	90.97
3	Хялганат	90.95